

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	7
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН
ТАНАА

2019.03.15 № 06/432
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайланг хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын дүн, дүгнэлтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 01-ээс 2019 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг, Г.Мөнхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/447 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Дээрх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна”, 16.4.5-д “агентлагийн дарга тус агентлагийн төсвийн” гэж заасны дагуу тус агентлагийн дарга Л.Бямбасүрэн төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлагийн урсгал зардлыг 2018 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс, Үйлдвэрлэлийн алба, Нисэх хөдөлгөөн үйлчилгээний албадын зардлыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталж навигацийн орлогоор санхүүжүүлдэг.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Улсын нисэхийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль болон бусад холбогдолтой хууль, эрхзүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив ХХК-ийн Веритех” програм хангамж ашигладаг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ. Дотоод хяналтын талаар доорх заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Тайлант оны дотоод аудит, хяналт шалгалтын хийх хуваарийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар ерөнхий газрын болон түүний харьяа 22 алба, салбар, хэлтэс нэгжид төлөвлөгөөт шатлалтыг 25, төлөвлөгөөт бус шалгалтыг 9 нийт 34 хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Дээрх дотоод аудитын шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг засаж залруулахаар 192 зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай үнэлэгдсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгов.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний 2018 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 341,853.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3,418.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь өмнөх онд 2,644.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгсөн, тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг, авлага материаллаг дүнтэй байсантай холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- ✚ Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “аж, ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх” зааврын дагуу хийх тайлангийн тэмдэглэл, тодруулгаас үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны тодруулга тайланг бэлтгэн илүүлээгүй;
- ✚ Эзэмших эрхтэй 6,162.8 сая төгрөгөөр үнэлэгдсэн газрыг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалын 5.5-д “дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгахдаа газар эзэмших болон ашиглах эрхтэй бол биет бус хөрөнгөөр бүртгэх бөгөөд цаашид элэгдүүлэхгүй” гэдгийг баримталж ажиллаагүй үндсэн хөрөнгөнд бүртгэсэн;
- ✚ Засгийн газрын 2017 оны 322, 2018 оны 150 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/6233 дугаар албан бичгийг үндэслэн Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувьд хөрөнгө оруулах 30,100.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Тус санхүүжилтийг бүртгэл тайлагналд стандарт, хууль, журмын дагуу хэрхэн тусгах талаар холбогдох эрх бүхий байгууллагуудаас /Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний аудитын газраас/ тодруулах шаардлагатай байсан тул санхүүгийн тайлан

хүргүүлэх хуулийн хугацаанд багтан орлогын албан татварын тооцооллыг хийгээгүйгээс татварын зардлыг 7,395.0 сая төгрөгөөр дутуу тооцоолсон зэрэг нийт 13,557.8 сая төгрөгийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулгыг журмын дагуу хүлээн авсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2. Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/сая төгрөг/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	566.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
Дүн		4	566.0	

2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны дараагийн тайлангийн аудитаар хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, цалингийн тооцоолол, шагнал, урамшуулал болон бараа, материал, үндсэн хөрөнгө, өмнөх оны акт, албан шаардлагын биелэлтийн асуудлыг авч үзэж, анхаарал хандуулна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Иргэний нисэхийн ерөнхий газар чиг, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2018 онд үйл ажиллагааны орлогыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 270/274 дугаар тушаалаар 316,769.1 сая төгрөгөөр батлагдснаас гүйцэтгэлээр 322,328.7 сая төгрөг буюу 101.8 хувийн биелэлттэй, үүнээс улсын төсөвт төвлөрүүлэх навигацгийн орлогыг 167,672.8 сая төгрөгөөр баталж 100 хувь төвлөрүүлэн ажилласан байна.

Харин урсгал зардлыг 118,282.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 30,813.5 сая төгрөг нийт 149,096.3 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 133,218.3 сая төгрөг буюу 89.3 хувийн биелэлттэй байна. Урсгал зардлын төсвөөс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг байгууллагын даргын тушаалаар 14,288.9 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж 9,045.7 сая төгрөг буюу 63.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн улсын төсвөөс агентлагийн урсгал зардалд 3,150.7 сая төгрөг батлагдаж 3,150.2 сая төгрөгийн буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа жилийн төсвийн төсөл /Бүтэн жилээр/
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /Хагас, бүтэн жилээр, сар улирал бүр/
- Тухайн жилийн төсөв орсон нэмэлт, өөрчлөлт /Тухай бүр/
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /Тухай бүр/
- Санхүүгийн тайлан /Хагас, бүтэн жилээр/
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /Бүтэн жилээр/
- Байгууллагын батлагдсан төсөв /Бүтэн жилээр/

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2,089.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 555.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн ба 2018 оны жилийн эцсийн байдлаар 81.4 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 *Балансын данстай холбоотой асуудал*

3.1.1 *Илрүүлэлт:*

Хойшлогдсон татварын хөрөнгө дансны үлдэгдэл 136.9 сая төгрөг байгаа ба тайлант онд ханшийн зөрүүний 383.2 сая төгрөгөөс өөр өөрчлөлт оруулаагүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үндсэн хөрөнгийн элэгдлээр татварын зөрүүгийн тооцоолол хийгээгүй нь Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам"-ын 5.4-т "Түр зөрүүг бүртгэхэд үүссэн хойшлогдсон татварын ... дансанд нь тодорхой хугацааны дараа нөхөгдөж үлдэгдэлгүй болно"; мөн журмын 5.6-д "Хойшлогдсон татварын дансны хөдөлгөөний дэлгэрэнгүй бүртгэлийг ... хөрөнгө, өр төлбөрийн данс бүрээр нарийвчлан хөтөлнө" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 *Эрсдэл:*

Үнэн зөв, тодруулга ба толилуулга батламж мэдэгдэл хангагдахгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, өр төлбөр, торгууль, хүү, алданги ихсэх

3.1.3 *Өгсөн зөвлөмж:*


Хойшлогдсон татварын дансны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, стандарт, хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллаж, санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлангуудыг бодитой үнэн, зөв, илэрхийлж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

3.2 *Зардалтай холбоотой асуудал*

3.2.1 *Илрүүлэлт:*

 Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлага болон мэргэжилтнүүдийн гадаад томилолтын зардалд 31.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д

“тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолын 2.2-т “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй;

✚ Гадаад, дотоод томилолтын зардлаас 333.8 сая төгрөгийг түүвэрлэн шалгахад дотоод томилолтын 26.9 сая төгрөгийн зардал батлагдсан төсөвгүй, мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6 дугаар зүйл “тооцооны маягт нөхөх заавар”-ын 6.2-д заасан мөнгөн урьдчилгааны тайлан гаргах гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл, тохиолдсон байх батламж мэдэгдэл хангагдаагүй, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт сулрах, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, сангийн сайдын холбогдох журмыг мөрдөн ажиллаж томилолтын төсөв, мөнгөн урьдчилгааны тайланг гаргаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, зөвлөмж өгөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

3.3 Авлагын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

✚ Дотоодын Хангарьд авиа компаниас авах 1997 онд үүссэн 3.8 сая, 'AIR FUTURE MONGOLIA-аас авах 2006 он үүссэн 4.0 сая, Транс-Өлгий ХХК-иас авах 2009 он үүссэн 27.2 сая, Моннис Эирсервис ХХК-иас авах 2014 онд үүссэн 18.7 сая нийт 53.7 сая төгрөгийн олон жил болсон авлага;

✚ Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудтай холбоотой 2005-2013 онд үүссэн 14.2 сая төгрөг, цалингийн урьдчилгааны хугацаа хэтэрсэн 2.1 сая төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу олгосон нөхөн олговрыг давхардуулан олгосноос үүссэн 11.0 сая төгрөг нийт 27.3 сая төгрөгийн авлага;

✚ Гэрээт ажлын 4 байгууллагатай холбоотой 118.7 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй авлага нийт 199.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдаагүй, найдваргүй эзэн холбогдогчгүй авлага ихсэх, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллага болон, хувь хүн, ажилтнуудтай холбоотой үүссэн авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгөх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болон цалингийн маргаантай холбоотой 5 хүнд 111.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн биелэлттэй холбоотой 1 байгууллагад 59.8 сая төгрөг нийт 171.5 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг, батламж мэдэгдэл хангагдаагүй, зардал ихсэх, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгууллагын чиг үүрэгт хамааралгүй зардал гарах эрсдэл үүсгэхгүй ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	59,702,014,736.79	67,065,468,195.50
1.1.2	Дансны авлага	25,633,462,214.15	28,798,697,952.42
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	595,488,690.00	4,652,672,534.07
1.1.4	Бусад авлага	5,459,820,487.07	9,600,199,134.20
1.1.5	Системийн авлага	7,970,557,357.39	
1.1.6	Бараа материал	3,863,532,704.78	4,324,619,466.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	784,952,232.81	1,964,771,458.01
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	104,009,828,422.99	116,406,428,740.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	55,678,543,356.56	40,544,592,333.01
1.2.2	Биет бус хөрөнгө	1,401,004,603.88	84,513,730,006.88
1.2.5	Дуусаагүй барилга	21,697,833,614.09	20,937,713,197.09
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	383,202,001.65	136,884,044.54
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	79,160,583,576.18	146,132,919,581.52
1.3	Нийт хөрөнгийн дүн	183,170,411,999.17	262,539,348,322.18
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	1,654,724,420.90	2,168,904,473.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	2,387,835,554.75	47,700.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,573,083,076.37	1,005,920,000.61
2.1.1.12	Бусад өглөг		4,644,820,541.34
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,615,643,052.02	7,819,692,714.95
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр /УОО/	3,367,649,364.32	8,624,092,723.66
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,367,649,364.32	8,624,092,723.66
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,983,292,416.34	16,443,785,438.61
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч		
2.3.3	-төрийн	225,569,216,113.02	311,396,167,829.97
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(51,382,096,530.19)	(65,300,604,946.40)
2.3.11	Эздийн өмчийн дүн	174,187,119,582.83	246,095,562,883.57
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	183,170,411,999.17	262,539,348,322.18

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	251,413,727,288.15	283,139,139,868.57
2	Борлуулалтын өртөг	37,631,379,826.17	73,299,807,424.43
3	Нийт ашиг (алдагдал)	213,782,347,461.98	209,839,332,444.14
4	Түрээсийн орлого	-	4,141,999.05
5	Хүүний орлого	1,427,823,205.26	2,584,111,876.91
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	26,736,418,280.39	32,217,783,292.54
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	154,295,292,042.39	173,379,065,445.33
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	61,858,710,981.20	86,763,108,825.10
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,609,644,722.11)	4,985,665,788.55
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(136,796,008.10)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	
17	Бусад ашиг (алдагдал)	-	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	24,182,941,201.93	(10,647,934,877.34)
19	Орлогын татварын зардал	4,987,598,703.39	555,914,703.41
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	19,195,342,498.54	(11,203,849,580.75)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	19,195,342,498.54	(11,203,849,580.75)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	19,195,342,498.54	(11,203,849,580.75)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	225,569,216,113.02			(61,469,310,942.34)	164,099,905,170.68
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(9,108,128,086.39)	(9,108,128,086.39)
2	Залруулсан үлдэгдэл				(70,577,439,028.73)	154,991,777,084.29
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				19,195,342,498.54	19,195,342,498.54
4	Өмчид гарсан өөрчлөлт					
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	225,569,216,113.02			(51,382,096,530.19)	174,187,119,582.83
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
2	Залруулсан үлдэгдэл				(51,382,096,530.19)	174,187,119,582.83
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(11,203,849,580.75)	(11,203,849,580.75)
4	Өмчид гарсан өөрчлөлт		2,115,463,787.55	83,711,487,929.40	(2,714,658,835.46)	(83,112,292,881.49)
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	225,569,216,113.02	2,115,463,787.55	83,711,487,929.40	(65,300,604,946.40)	246,095,562,883.57

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	251,228,142,059.63	324,217,220,890.81
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	241,735,244,502.99	274,338,238,921.58
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	221,704,706.00	90,666,690.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	7,541,546,289.00	26,939,758,237.21
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,729,646,561.64	22,848,557,042.02
1.2	Мөнгөн зарлагын дүн	228,676,989,020.22	309,930,423,217.72
1.2.1	Ажиллагчдад төлсөн	26,718,424,998.36	29,273,352,799.54
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,234,855,219.37	5,796,629,366.51
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,007,018,934.52	3,680,805,434.74
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,286,357,530.91	4,494,589,998.50
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,636,144,660.08	2,619,680,280.99
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	13,589,037,083.14	10,066,383,255.86
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,941,568,170.22	1,864,422,908.46
1.2.9	Бусад мөнгөн зарлага	171,263,582,423.62	252,134,559,173.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	22,551,153,039.41	14,286,797,673.09
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	1,427,823,205.26	2,584,111,876.91
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,427,823,205.26	2,584,111,876.91
2.2	Мөнгөн зарлагын дүн	6,351,797,647.50	9,507,456,091.29
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн-өөрийн хөрөнгө	6,330,584,717.50	9,405,314,481.29
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,212,930.00	102,141,610.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,923,974,442.24)	(6,923,344,214.38)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,627,178,597.17	7,363,453,458.71
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	42,074,836,139.62	59,702,014,736.79
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	59,702,014,736.79	67,065,468,195.50

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.15	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний алба			САГ-2019/144/14-ТӨҮГ	Сая төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Хойшлогдсон татварын хөрөнгө дансны үлдэгдэл 136.9 сая төгрөг байгаа ба тайлант онд ханшийн зөрүүний 383.2 сая төгрөгөөс өөр өөрчлөлт оруулаагүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үндсэн хөрөнгийн элэгдлээр татварын зөрүүгийн тооцоолол хийгээгүй байна.	136.9	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга, Ерөнхий нягтлан, ҮНББА-ны дарга	Л.Бямбасүрэн, Н.Наранцэцэг, С.Отгонбаяр
Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлага болон мэргэжилтнүүдийн гадаад томилолтын зардалд 31.0 сая төгрөгийг зарцуулсан, Гадаад, дотоод томилолтын зардлаас 333.8 сая төгрөгийг түүвэрлэн шалгахад дотоод томилолт 26.9 сая төгрөгийн зардал батлагдсан төсөвгүй, мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй байна.	57.9	Зөвлөмж		
Санхүүгийн тайланд бүртгэлтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн, хуулийн хэлтэс болон шүүхэд шилжүүлсэн хувь хүн болон аж, ахуйн нэгж байгууллагатай холбоотой 196.6 сая төгрөгийн авлага байна.	199.7	Зөвлөмж		
Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болон цалингийн маргаантай холбоотой 5 хүнд 111.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн биелэлттэй холбоотой 1 байгууллагад 59.8 сая төгрөг нийт 171.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	171.5	Зөвлөмж		
Зөвлөмжийн дүн	566.0			

